

# Монгол ардын үлгэр

## Монгольские народные сказки

Пособие подготовил **Вадим Понарядов**

*Метод чтения Ильи Франка*

### ЯДУУ ХҮҮ (МАЛЬЧИК-БЕДНЯК)

Урьд нэг ядуу хүү байжээ (раньше один бедный мальчик был; *байх* — *быть*). Нэг нохойтой, нэг сүхтэй юм санж (с одной собакой, с одним топором был = у него были только собака и топор; *нохой* — *собака*; *сүх* — *топор*). Нохойтойгоо хамт (вместе со своей собакой) зэлүүд газар явж (по безлюдной земле ходя; *газар* — *земля*; *явах* — *идти, ходить*) нохой нь зээр гөрөөс барьж ирэхэд (когда его собака ловила антилоп; *зээр* — *антилопа-дзерен*; *гөрөөс* — *антилопа*; *барих* — *ловить*; *ирэх* — *приходить* /в данном случае указывает на направленность действия: «ловила и приходила [к хозяину]»/), түүнийг хуваан идэж амьдардаг байв (это разделив и съев, жил: «живущий был»; *хуваах* — *делить*; *идэх* — *есть, съесть*; *амьдрах* — *жить*).

Нэг өдөр (однажды: «один день») нохой нь удаж удаж (собака его долго-долго отсутствовал; *удах* — *задерживаться*) нэг зээрийн махтай иржээ (пришла с мясом одного дзерена; *мах* — *мясо*; *ирэх* — *приходить*). Ирээд (прибежав) нөгөө хүүгийн ханцуйнаас (того мальчика за рукав; *ханцуй*) зууж чангаагаад (хватая, потащив; *зуух* — *кусать*; *чангаах* — *тянуть, тащить*; *тормошить*), буцаад жаахан явж гэнэ (возвращаясь, немного бежит; *явах* — *идти*; *гэнэ* — *пересказывательная частица*). Мөн дахин ирж (также опять подбегая) чангаагаад явж гэнэ (идет и тащит). Тэгсээр яваад (потом убежав)

бүр далд оров (совсем скрылась; *далд* — *тайный*; *орох* — *входить*; *далд орох* — *скрывается, прятаться*).

**Урьд нэг ядуу хүү байжээ. Нэг нохойтой, нэг сүхтэй юм санж. Нохойтойгоо хамт зэлүүд газар явж нохой нь зээр гөрөөс барьж ирэхэд, түүнийг хуваан идэж амьдардаг байв.**

**Нэг өдөр нохой нь удаж удаж нэг зээрийн махтай иржээ. Ирээд нөгөө хүүгийн ханцуйнаас зууж чангаагаад, буцаад жаахан явж гэнэ. Мөн дахин ирж чангаагаад явж гэнэ. Тэгсээр яваад бүр далд оров.**

Хүү тэгэхээр (мальчик тогда):

— Намайг цуг яв гэсэн биш байгаа (чтобы я вместе пошел, не говорит ли она: «меня “вместе иди” не сказавшая [ли] пребывающая»?; *биш* — *не*; *байх* — *быть*) гэж бодоод (подумав: «говоря, подумав») нохойнхоо хойноос дагаж (следуя за своей собакой; *хойно* — *за*; *дагах* — *следовать*) явжээ (пошел). Тэгтэл нохой нь (между тем его собака; *нь* — *его/ее* (*притяжательная частица 3-го лица*)) уулын ар луу даваад явжээ (пошла, перейдя на северный склон горы; *уул* — *гора*; *ар* — *задняя/северная сторона*; *давах* — *переваливать, переходить*). Хүү хойноос нь (мальчик за ней) уулын оройд гарч (выйдя на вершину горы; *орой* — *вершина, верхушка*) өнгийгөөд харжээ (подняв голову, посмотрел; *өнгийх/өндийх* — *приподниматься; поднимать голову*; *харах* — *смотреть*). Харвал, уулын ард том цагаан азарга шиг юм зогсож байжээ (смотрит — на северном склоне горы стоит что-то, словно большой белый жеребец; *том* — *большой*; *азарга* — *жеребец*; *шиг* — *как, словно*; *юм* — *вещь, нечто*; *зогсох* — *останавливаться*). Сайн ажиглавал (хорошенько пригляделся; *ажиглах*), азарга биш бололтой (не жеребец, пожалуй). Нохой нь нэг эвхэрч дөхөж очоод л (собака его только раз повернувшись, приблизилась; *эвхрэх* — *поворачиваться*; *дөхөх* — *приблизиться*; *очих* — *пойти*; *л* — *именно, как раз /выделительная*

*частица/)* буцаж ирээд байна гэнэ (и уже вернулась обратно: «возвращаясь пришедши есть»).

**Хүү тэгэхээр:**

— Намайг цуг яв гэсэн биш байгаа гэж бодоод нохойнхоо хойноос дагаж явжээ. Тэгтэл нохой нь уулын ар луу даваад явжээ. Хүү хойноос нь уулын оройд гарч өнгийгөөд харжээ. Харвал, уулын ард том цагаан азарга шиг юм зогсож байжээ. Сайн ажиглавал, азарга биш бололтой. Нохой нь нэг эвхэрч дөхөж очоод л буцаж ирээд байна гэнэ.

За энэ ч (ну, это; ч — же; тоже; даже /присоединительная частица/) дэлт чоно гээч байх (был: «будет» так называемый гривастый волк = матерый волк, у которых обычно бывает большая грива; дэл — грива; чоно — волк; гээч — так называемый). Үүнийг дийлэх юмгүй (его одолеть без возможности: «без вещи») нохойноосоо салах байх (собаку потерять придется: «будет»; салах — разобщаться, отделяться) гэж бодоод буцаж (подумав, возвращаясь), байсан газраа иржээ (к себе домой: «на свое место пребывания» пришел; газар — место). Хүү байсан газраа ирээд (мальчик, пришедши домой), сүхээ авч явсангүй тоогүй боллоо (взяв топор, не пошел, стал горевать; тоогүй — печальный; болох — становится), тэгвэл би алах байж (тогда я убивать буду; алах — убивать) гэж бодоод (подумав: «говоря, подумав») гутарч суужээ (в смятении сел; гутрах — прийти в смятение/замешательство).

Тэгтэл оройхон нохой нь (между тем, вечером собака его) дөнгөж амьтай гэлдэрч ирэв (еле живая приплелась; дөнгөх — справляться кое-как, с трудом; амь — жизнь, дыхание; гэлдрэх — брести). Тэгэхэд нь өрөвдөөд (тогда с жалостью; өрөвдөх — сочувствовать) нохойдоо хоол өгчээ (своей собаке он дал еду). Нохой нь идэж ч чадалгүй үхжээ (собака и поесть не смогла, умерла; идэх — есть; ч — и, же; также; даже /присоединительная частица/; чадах — мочь; үхэх — умирать). Хүү “нохойноосоо салав, амьдрах

аргагүй болов” гэж бодоод (“собаку потерял, без средств к существованию остался”, — подумал мальчик; *амьдрах — жить, существовать; арга — средство, способ; болох — становиться*) сүхээ аваад явжээ (взял топор и пошел). Явахдаа (когда шел) өнөөх дэлт чонотой газраар дайрчээ (стал проходить местом, где был тот гривастый волк: «местом с тем гривастым волком»); *дайрах — заходить, заезжать*). Өнөө дэлт чоно ч үхсэн байв гэнэ (тот гривастый волк тоже умер, оказывается).

**За энэ ч дэлт чоно гээч байх. Үүнийг дийлэх юмгүй нохойноосоо салах байх гэж бодоод буцаж, байсан газраа иржээ. Хүү байсан газраа ирээд, сүхээ авч явсангүй тоогүй боллоо, тэгвэл би алах байж гэж бодоод гутарч суужээ.**

**Тэгтэл оройхон нохой нь дөнгөж амьтай гэлдэрч ирэв. Тэгэхэд нь өрөвдөөд нохойдоо хоол өгчээ. Нохой нь идэж ч чадалгүй үхжээ. Хүү “нохойноосоо салав, амьдрах аргагүй болов” гэж бодоод сүхээ аваад явжээ. Явахдаа өнөөх дэлт чонотой газраар дайрчээ. Өнөө дэлт чоно ч үхсэн байв гэнэ.**

Хэрэв би нохойтойгоо цуг сүхээ авчирсан бол (если бы я вместе с собакой топор принес бы; *авчрах — приносить*) нохой минь амьд байх байж (собака моя живая была бы) гэж гашуудсаар (горюя; *гашуудах*) хүү цааш явжээ (мальчик дальше пошел). Нэг өдөр (однажды: «один день») уулын араас (с северного склона горы) баахан хонь (несколько овец) уруудан (двигаясь вниз; *уруу — вниз; уруудах — идти вниз*) тал руу бууж явна гэнэ (на равнину спускаясь, идут; *тал — равнина, степь; буух — спускаться*). Юу ч гэсэн (ну, что же) айлд очих нь (домой идут; *айл — стоянка кочевников, группа юрт*) гэж бодоод явж байжээ (думая, он шел: «идя был»). Гэтэл хонид тал руу ороод (однако когда овцы вошли на равнину; *гэтэл — однако; орох — входить*) үзэгдэхээ болив (видеться перестали = исчезли из виду; *үзэх — видеть; үзэгдэх — видеться, виднеться*). Айл ч үзэгддэггүй гэнэ (и юрт не

видно). Тэгэхээр нь (тогда) хонь явж байсан газарт (на место, где шли овцы; *газар — место*) яваад иржээ (пришел: «пойдя пришел»). Хүрээд ирсэн дан чонын мөр байв (там был только волчий след: «достигнув, пришедших только волков след был»). Тэд явсаар (они, двигаясь) нэг их том нүх рүү орсон байна гэнэ (в одну очень большую нору вошли; *их — очень; том — большой; нүх — дыра; орох — входить*). Тэгэхээр хүү (тогда мальчик) эднээс нохойнхоо өсийг авна гээд (собираясь отомстить им за свою собаку: «от этих собаки своей мщение возьму, говоря»; *өс/өшөө — мечь, мщение; авах — брать*) сүхээ бариад (взяв свой топор; *барих*) отоод суужээ (сел караулить; *отох — подстергать; суух — сидеть, садиться*).

**Хэрэв би нохойтойгоо цуг сүхээ авчирсан бол нохой минь амьд байх байж гэж гашуудсаар хүү цааш явжээ. Нэг өдөр уулын араас баахан хонь уруудан тал руу бууж явна гэнэ. Юу ч гэсэн айлд очих нь гэж бодоод явж байжээ. Гэтэл хонид тал руу ороод үзэгдэхээ болив. Айл ч үзэгддэггүй гэнэ. Тэгэхээр нь хонь явж байсан газарт яваад иржээ. Хүрээд ирсэн дан чонын мөр байв. Тэд явсаар нэг их том нүх рүү орсон байна гэнэ. Тэгэхээр хүү эднээс нохойнхоо өсийг авна гээд сүхээ бариад отоод суужээ.**

Өглөө чоно гараад ирж явна гэнэ (утром волки выходят: «выйдя приходя идут»). Түрүүчийн чоноос эхлээд (с первого волка начав; *эхлэх*), цувран гарахад нь (когда они выходили друг за другом; *цуврах — идти друг за другом, гуськом, вереницей*) цугийнх нь хүзүүг тас цавчжээ (у всех у них шею разрубил; *хүзүү — шея; тас цавчих — разрубить*). Хамгийн сүүлд (в самом конце; *сүүл — конец; хвост*) нэг их том юм (кто-то очень большой: «одно очень большое нечто») архирч хүрч ирээд л (только выскочил, рыча; *архирах — рычать; хүрэх — доходить, достигать; ирэх — приходиться; л — выделительная частица*) буцаад байна гэнэ (и уже спрятался обратно: «вернувшись есть»). Энэ лав азарган чоно байх (это наверняка волк-вожак;

*лав — точно, достоверно*), одоо би идүүлэх биз (теперь меня съест ведь; *идэх — есть, съесть; идүүлэх — позволить съесть; биз — ведь*) гэж бодоод (подумав) том чулуу бөмбөрүүлэн (*большой камень покотив*) нүхийг таглаад яваад өгчээ (заткнул нору и ушел: «нору заткнув, уйдя дал»; *таглах — затыкать, закупоривать; өгөх — давать*). Явсаар нэг айлд ортол (идя, в одно селение когда вошел) нэг мэргэн хүн байв ([там] один мудрый человек был).

**Өглөө чоно гараад ирж явна гэнэ. Түрүүчийн чоноос эхлээд, цувран гарахад нь цугийнх нь хүзүүг тас цавчжээ. Хамгийн сүүлд нэг их том юм архирч хүрч ирээд л буцаад байна гэнэ. Энэ лав азарган чоно байх, одоо би идүүлэх биз гэж бодоод том чулуу бөмбөрүүлэн нүхийг таглаад яваад өгчээ. Явсаар нэг айлд ортол нэг мэргэн хүн байв.**

— Би танаар ном заалган сууя (*я поучусь у вас книжной мудрости: «я вами книги прося преподавать, посижу-ка»; та — вы; ном — книга; заах — показывать, обучать; заалгах — просить научить; учиться; суух — сидеть*) гэж гуйжээ (попросил он: «говоря попросил»). Тэр хүн зөвшөөрч (когда тот человек согласился; *зөвшөөрөх*) хэдэн жил ном заалгаж (несколько лет учась книжной мудрости) нэгэн өдөр багшдаа урьдах түүхэн явдлаа ярьжээ (однажды рассказал учителю свою прежнюю историю; *багш — учитель; урьд — раньше, прежде; түүх — история; явдал — дело, действие; случай*). Багш нь (учитель его):

— Чи тэгвэл (ты тогда) ном заасанд болохгүй (в книжном учении не будешь; *болох — становиться, быть*) харин сур харвах сургууль сайн хий (однако хорошо учись стрелять из лука; *сур харвах — стрелять из лука; сургууль — школа, учеба; хийх — делать; сургууль хийх — учиться*). Хэт нь (в будущем) чи тэр чонотой (ты с тем волком) хэзээд дайралдана (когда-нибудь сразишься). Тэгэхэд чи сайн харвахгүй бол (тогда если ты не будешь хорошо

стрелять) өөрөө идүүлнэ (самого съедят: «себя съестъ позволишь») гэж захив (дал наказ; *захих* — *заказывать; давать наказ*).

— Би танаар ном заалган сууя гэж гуйжээ. Тэр хүн зөвшөөрч хэдэн жил ном заалгаж нэгэн өдөр багшдаа урьдах түүхэн явдлаа ярьжээ. Багш нь:

— Чи тэгвэл ном заасанд болохгүй харин сур харвах сургууль сайн хий. Хэт нь чи тэр чонотой хэзээд дайралдана. Тэгэхэд чи сайн харвахгүй бол өөрөө идүүлнэ гэж захив.

Хүү тэгээд нум, сум харвах сургууль их сайн сурчээ (мальчик тогда стрелять из лука очень хорошо научился; *нум* — *лук; сум* — *стрела; сурах* — *учиться*). Тэгээд өмнөх юмаа мартчихсан байж байтал (затем, когда о прежнем забыл; *өмнө* — *раньше, прежде; юм* — *вещь, нечто; мартах* — *забывать*) тэр зүгт олон аянчин явах болжээ (в ту сторону много путников идти собрались). Аянчийг өнөө хүү даргалж явах болжээ (путников тот мальчик вести собрался: «ведя идти стал»). Ингээд явж байтал (когда так шли) өнөө чонотой таарсан хөтөл нь таарчээ (попался перевал, где встречался с тем волком; *хөтөл* — *перевал, седловина; таарах* — *попадаться, встречаться*). Энэ чинь өнөө багшийн хэлдэг үнэн болох нь (это вот, что говорил тот учитель, правдой будет; *хэлэх* — *говорить, сказать; үнэн* — *правда*) гэж бодоод (подумав) нөхдөдөө өмнөх явдлаа ярьжээ (своим товарищам прежний случай рассказал; *нөхөр* — *товарищ*). Тэгээд бид эндээ бууж (тогда мы здесь спустившись) майхнаа шаая (свою палатку давайте поставим; *майхан* — *палатка, шатер; шаах* — *вбивать*) гээд буун (сказав, спускаясь; *гэх* — *говорить; буух* — *спускаться*), ээлжээр хамар дээр гарч (по очереди на выступ возвышенности выйдя; *ээлж* — *смена, очередь; ээлжээр* — *по очереди; хамар* — *нос; мыс; дээр* — *на*) бараа харав (оглядели окрестности; *бараа* — *предмет, виднеющийся вдали*).

Хүү тэгээд нум, сум харвах сургууль их сайн сурчээ. Тэгээд өмнөх юмаа мартчихсан байж байтал тэр зүгт олон аянчин явах болжээ. Аянчийг өнөө хүү даргалж явах болжээ. Ингээд явж байтал өнөө чонотой таарсан хөтөл нь таарчээ. Энэ чинь өнөө багшийн хэлдэг үнэн болох нь гэж бодоод нөхдөдөө өмнөх явдлаа ярьжээ. Тэгээд бид эндээ бууж майхнаа шаая гээд буун, ээлжээр хамар дээр гарч бараа харав.

Хэд хоносны хойно (через несколько дней: «ночевок»; *хонох* — *ночевать*) цаад жалга өгсөөд (по следующей ложбине поднимаясь; *жалга* — *ложбина, овраг; сухое русло реки; өгсөх* — *идти вверх по реке; подниматься на гору*) том бух ирж явна гэж нэг нь хэлж ирэв (один из них прибежал с сообщением, что приближается большой бык: «“большой бык приходя идет”, — говоря, один из них сказав пришел»; *бух* — *бык; хэлэх* — *говорить, сказать*). Тэгээд сэжиг авч (тогда, засомневавшись; *сэжиг* — *сомнение, подозрение; авах* — *брать*) тэр муу санаат чоно (тот злонамеренный волк; *муу* — *плохой; санаа* — *мысль, намерение*) зүсээ хувилгаж байгаа байх (свой облик изменил, должно быть: «свой облик изменив пребывающий будет») гэж нөхдөдөө хэлээд (сказав своим товарищам) нум сумаа авч (взяв лук и стрелы) хөтөл дээр гарчээ (вышел на перевал). Тэгтэл үнэхээр (между тем действительно) том бух айсуй гэнэ (большой бык приближается). Юу ч болсон харвана (все равно выстрелю) гэж бодоод (подумав) шагайж шагайж харваад орхижээ (целился, целился, и выстрелил; *орхих* — *бросать*). Тэгтэл үхэр цээж (тогда бычья грудь), чонон бөгс болж (волчьим задом став) салаад (отделившись) газрын уруу өнхөрч өнхөрч тогтжээ (к земле катясь, катясь, остановилась). Тэгээд нөхдөө дагуулан (тогда, поведя за собой товарищей; *дагах* — *следовать; дагуулах* — *вести за собой*) хүрч ирвэл (когда подошел; *хүрэх* — *доходить, достигать; ирэх* — *приходить*) өнөө чоно мөн байв (был именно тот волк). Тэгсэн нэг бух барьж идээд (это одного быка поймав и съев) цээжийг нь хөндийлөн (грудь его выев; *хөндийлөх* — *опорожнить; выдолбить*) түүнийг цээжиндээ углаад (ее на грудь свою одев; *углах* —



*вдевать, вставлять*) явж байсан ажээ (ходил, оказывается). Тэгээд дайснаа дараад (затем, победив своего врага; *дайсан — враг; дарах — давить; одолевать, побеждать*) аян жиндээ сайн яваад (хорошо совершив свое путешествие: «в путешествии-караване своем хорошо сходилв»; *аян — дорога, путь; путешествие; жин — караван*) адал (эд) хогшил ихтэй ах дүү олонтой болж (обзаведясь большим состоянием и многими родственниками; *эд — вещь; товар; хогшил — имущество; эд хогшил — имущество, состояние; их — большой; ах — старший брат; дүү — младший брат, младшая сестра; олон — много; болох — становиться*) амар сайхан жаргажээ (наслаждался спокойствием и благополучием; *жаргах — наслаждаться*).

**Хэд хоносны хойно цаад жалга өгсөөд том бух ирж явна гэж нэг нь хэлж ирэв. Тэгээд сэжиг авч тэр муу санаат чоно зүсээ хувилгаж байгаа байх гэж нөхдөдөө хэлээд нум сумаа авч хөтөл дээр гарчээ. Тэгтэл үнэхээр том бух айсуй гэнэ. Юу ч болсон харвана гэж бодоод шагайж шагайж харваад орхижээ. Тэгтэл үхэр цээж, чонон бөгс болж салаад газрын уруу өнхөрч өнхөрч тогтжээ. Тэгээд нөхдөө дагуулан хүрч ирвэл өнөө чоно мөн байв. Тэгсэн нэг бух барьж идээд цээжийг нь хөндийлөн түүнийг цээжиндээ углаад явж байсан ажээ. Тэгээд дайснаа дараад аян жиндээ сайн яваад адал (эд) хогшил ихтэй ах дүү олонтой болж амар сайхан жаргажээ.**

---

*Полностью книгу можно купить на сайте [www.franklang.ru](http://www.franklang.ru) в соответствующем языковом разделе (монгольский язык), в подразделе «Тексты на монгольском языке, адаптированные по методу чтения Ильи Франка»*